

УУЛ УУРХАЙН АВРАХ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Б.Батзориг

Дотоод хэргийн их сургуулийн 8014 дүгээр дамжааны суралцагч, ахмад

Товч агуулга: Аливаа улс орны эрдэс баялгийн нөөц нь эдийн засгийн өсөлтийг хангах бодлого хийгээд тухайн улсын тогтвортой хөгжлийн үндсэн суурь болж ирсэн. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр уурхай, эрдэс баялгийн түүхий эдийн эрэлт, хэрэгцээ өс ч ашигт малтмал олборлох, боловсруулах үйлдвэрүүд нэмэгдэж байгаа нь өнөөгийн нөхцөлд ашигт малтмалын нөөцийг ашиглах шаардлага тулгарч байна. Сүүлийн жилүүдэд байгалийн аюулт үзэгдэл болон хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй гамигийн аюулын тоо давтамж, хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэж хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх алдагдаж Онцгой байдлын байгууллага Олон Улсын стандартад нийцсэн техник тоног төхөөрөмж ашиглах мөн уул уурхайн аврах ажиллагааны удирдлага зохион байгуулалтын талаар судлах зайлиггүй шаардлага тулгарч байна.

Abstract: The mineral resources of any country have been the main basis for the policy of ensuring economic growth and sustainable development of the country. In the territory of Mongolia, the demand and demand for raw materials for mining and mineral resources is increasing, but the number of mineral extraction and processing industries is increasing. In recent years, the frequency and magnitude of disasters caused by natural hazards and human error have been increasing year by year, and people's right to live in a healthy and safe environment has been lost. there is an urgent need.

Түлхүүр үг: Эрдэс баялгийн, эдийн засгийн, Монгол Улсын, уурхай, гамигийн, Онцгой байдлын байгууллага, уул уурхайн.

Keywords: Mineral wealth, economic, Mongolia, mine, disaster, Emergency Organization, mining.

Оршил: Уул уурхайн салбар нь дотоодын нийт бүтээгдэхүүний 24%, экспортын 85%, татварын орлогын 22%, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 72%, ажиллах хүчний 5.3% бий болгодог Монголын эдийн засгийн тэргүүлэх салбар юм.

Уул уурхайн салбарт 10 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, ихэнх хувийг хагас боловсруулсан, эсхүл түүхий хэлбэрээр экспортод гаргаж байна. Эдгээр бүтээгдэхүүнийг олон улсын зах зээл дээр өрсөлдөх чадвартай болгохын тулд өртөг зардлыг бууруулах, нэмүү өртөг шингээж гүн боловсруулах шаардлагатай. Үүний тулд дотоодын боловсруулах үйлдвэрүүдийг барьж байгуулах, зам тээвэр, цахилгаан болон усан хангамжийн дэд бүтцийг бүрдүүлэн үйлдвэр барих бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Манай улсын хэмжээнд уул уурхайтай холбоотойгоор сүүлийн 10 жилд дунджаар 369 осол гарч, мөн 404 хүн үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчинд өртөж, 70 орчим хүн нас барсан статистик мэдээлэл байна. Ослын шалтгааныг гарсан орчноор нь авч үзвэл уурхайн талбайд болон үйлдвэрлэлийн талбайд нийт ослын 51 буюу 74 хувь, хүчин зүйлээр нь авч үзвэл ажлын байрны орчин, техник технологи, удирдлагын тогтолцоо зэрэг нь нийт ослын 48 буюу 65,8 хувийг тус тус эзэлж байна.

Уурхай байгуулах гэдэг нь цогц үйл ажиллагаа бөгөөд уул уурхайн төслийн техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, дэд бүтэц, барилгын ажлын үе шат ордог. Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах үе шат нь ихэвчлэн тойм судалгаа, урьдчилсан ба эцсийн судалгаа зэрэг алхмуудын дагуу хийгдэж, мэргэжлийн өндөр туршлагатай хүмүүс оролцдог.

Нэг. Уул уурхайн аврах ажиллагааны удирдаллагын, аврах ажиллагаа зохион байгуулалт

Аюулын үед хүн, эд хөрөнгийг авран хамгаалах, эрж хайх, голомтоос гаргах, нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх, хор уршгийг арилгах үйл ажиллагааг зохион байгуулахад аврах ажиллагаа, удирдлага зохион байгуулалт маш чухал үүрэгтэй. Ослын үеийн удирдагчаар тухайн уурхай, үйлдвэр, аж ахуйн нэгжийн ерөнхий инженер ажиллах бөгөөд түүний эзгүйд диспетчер уг үүргийг түр гүйцэтгэнэ⁷⁹.

Ослын үеийн удирдагчийн гаргасан шийдвэрийг тухайн объектын ажилтнууд болон аврах ажиллагаанд оролцож буй албан хаагчид заавал биелүүлнэ. Аврах ажиллагааны ерөнхий удирдагчаар төв, орон нутгийн Онцгой байдлын газар, Аврах тусгай болон Уул уурхайн аврах ангиас шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах чиг үүрэгтэй томилогдсон албан хаагч ажиллана⁸⁰.

Ослын үеийн удирдагч, аврах ажиллагааны ерөнхий удирдагч нар

⁷⁹ Уурхай, уулын үйлдвэр, аюултай объектод аврах ажиллагааг зохион байгуулах журам

⁸⁰ Уул уурхайн аврах ангийн дүрэм

холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулан үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан шуурхай ажиллагааны төлөвлөгөө боловсруулж даалгаврыг Уул уурхайн аврах ангийн аврах ажиллагааны удирдагчид бичгээр өгнө.

Уул уурхайн аврах ангийн аврах ажиллагааны удирдагч, Ослын үеийн удирдагч нарын санал зөрсөн тохиолдолд Ослын үеийн удирдагчийн шийдвэрийг баримтална. Уул уурхайн аврах ангийн аврах ажиллагааны удирдагч “Шуурхай ажиллагааны дэвтэр”-т өөрийн саналаа бичнэ.

Аюул ослын үед тусгай мэргэжлийн албадыг зохион байгуулж ажиллуулах⁸¹

Уурхай, уулын үйлдвэр, үйлдвэрлэлийн аюултай объектод тохиолдсон олон хоног үргэлжилсэн, хүндэрсэн аюул ослын үед аврах ажлыг шуурхай удирдах, аврагчдын тусгаарлагч шүүгч баг, багаж тоног төхөөрөмжийг цэнэглэх, шалгаж тохируулах, ажилд бэлдэх, шаардлагатай материал, хэрэгслээр хангах, холбоог зохион байгуулах, уурхайн агаарын найрлагыг хянах, инженерийн тооцоо, судалгаагаар хангах зорилгоор Шуурхай удирдлагын төвөөс гадна бусад тусгай мэргэжлийн албадыг байгуулж ажиллана.

Үүнд:

1. Газрын гүний удирдлагын төв;
2. Инженерийн алба;
3. Лаборатори;
4. Хангалт үйлчилгээний алба.

5. Тусгай мэргэжлийн албадын дарга нар Ослын үеийн удирдагчийн шууд удирдлага дор ажиллана.

Уурхайн “Аврах ажиллагаа”-г тодорхой үе шаттайгаар зохион байгуулдаг

- Аюул ослын эхний үе шатанд гүйцэтгэх зохион байгуулалтын ажиллагаа.
- Аврах ажиллагааны үед холбоо зохион байгуулах
- Аюул ослын үед тусгай мэргэжлийн албадыг зохион байгуулж ажиллуулах
- Аврах бүлгийн шуурхай ажиллагаа
- Өндөр хэмийн халуунтай нөхцөлд аврах ажиллагаа зохион байгуулах

Ослын үеийн удирдагчаар тухайн уурхай, үйлдвэр, аж ахуйн нэгжийн ерөнхий инженер ажиллах бөгөөд түүний эзгүйд диспетчер уг үүргийг түр гүйцэтгэнэ. Ослын үеийн удирдагчийн гаргасан шийдвэрийг заавал биелүүлнэ.

Аврах ажиллагааны ерөнхий удирдагчаар төв, орон нутгийн Онцгой байдлын газар, Аврах тусгай болон Уул уурхайн аврах ангиас шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах чиг үүрэгтэй томилогдсон албан хаагч ажиллана.

Аврах ажиллагааны зохион байгуулалт

Ослын үеийн удирдагч, аврах ажиллагааны ерөнхий удирдагч нар холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулан үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан шуурхай ажиллагааны

⁸¹ Эрэн хайх, аврах ажиллагааны байгууллагын стандарт

төлөвлөгөө боловсруулж даалгаврыг Уул уурхайн аврах ангийн аврах ажиллагааны удирдагчид бичгээр өгнө. Уул уурхайн аврах ангийн аврах ажиллагааны удирдагч, Ослын үеийн удирдагч нарын санал зөрсөн тохиолдолд Ослын үеийн удирдагчийн шийдвэрийг баримтална. Уул уурхайн аврах ангийн аврах ажиллагааны удирдагч “Шуурхай ажиллагааны дэвтэр”-т өөрийн саналаа бичнэ.

Аюул, ослын үед уурхай, үйлдвэр, аж ахуйн нэгжийн удирдлага, холбогдох мэргэжилтнүүдийн гүйцэтгэх үүрэг, ажиллагсдын аюулгүй газарт очих зам, үйл ажиллагааг “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-өөр тодорхойлно. Ослын үеийн удирдагч эхний ээлжинд “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-нд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх ба уурхайгаас гараагүй хүний тоо, гэмтсэн байж болох хүний байрлал, нөхцөл байдал, агааржуулалтын горим, аюулын бүс зэргийг тодорхойлно.

Ослын үеийн удирдагч аврах ажиллагаанд дараах зарчмыг баримтлана:

1. Эхний ээлжинд уурхай, үйлдвэр, аж ахуйн нэгжийн “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-нд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ;

2. Аюул ослыг арилгах үр дүнтэй аргыг тодорхойлох;

3. Аюул ослын голомт дээр шаардлагатай хүч хэрэгслийг төвлөрүүлэх, зөв хуваарилах;

4. Аврах ажиллагаа явуулж байгаа газартай тасралтгүй холбоотой байж, нөхцөл байдлыг тодруулж, шуурхай удирдлагаар хангах;

5. Шуурхай ажиллагааны биелэлтийг хангах.

Ослын үеийн удирдагч аврах ажиллагааны удирдагчийг дараах мэдээллээр хангасан байна:

1. Аюул ослын төрөл, болсон газар, үүссэн цаг хугацаа, өртсөн бүс;

2. Өртсөн хүний тоо, тэдний байж болох байрлал;

3. Агаарын урсгалын чиглэл, аюулын бүсэд өгч буй агаарын хэмжээ;

4. Уул уурхайн аврах ангийг ирэхээс өмнө авсан арга хэмжээ, хүрсэн үр дүн;

5. Аврах бүлгийн явах чиглэл, замын малталтын нөхцөл байдал;

6. Уурхайд байгаа аюул осол арилгах зориулалттай тоног төхөөрөмжийн байршил⁸².

Аврах ажиллагааны зохион байгуулалт

Газрын дор болон үзэгдэх орчингүй, хязгаарлагдмал, агааргүй, хорт хийтэй, нуралтай орчинд аврах ажиллагаа явуулахдаа тусгаарлагч шүүгч багтай 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй бүлгийг ажиллуулна. Аврагчид нь зөвхөн нэг бүлгийн аврагчид байна. Тусгаарлагч шүүгч багтай ажиллах албан хаагч нь эрүүл мэндийн шалгуур үзүүлэлтийг хангасан, сургалтад хамрагдаж баг эзэмших эрх авсан байна. Багтай ажиллах эрхгүй албан хаагчийг

⁸²Уурхай, уулын үйлдвэр, аюултай объектод аврах ажиллагааг зохион байгуулах журам

агааргүй орчинд ажиллуулахыг хориглоно.

Тусгаарлагч шүүгч багтай аврагчдын ээлжинд ажиллах хугацаа нь багны хүчин чадлаас шалтгаалах ба цэвэр агааргүй орчинд 4 цагаас хэтэрч болохгүй

Аюул ослын төрөл, хаана үүссэн талаар баттай мэдээлэл байхгүй тохиолдолд зөвхөн хүмүүсийг аврах ажлыг гүйцэтгэх ба зэрэгцэн нөхцөл байдлыг тодруулах хайгуулын ажиллагааг зохион байгуулна.

Ослын үеийн удирдагч Уул уурхайн аврах ангийн бие бүрэлдэхүүнд аврах ажиллагааны удирдагчаар дамжуулан үүрэг даалгаврыг өгнө. Уурхай, үйлдвэр, аж ахуйн нэгжийн ажилтнуудыг аюул ослын бүсэд ажиллуулахдаа аврах ажиллагааны ерөнхий удирдагчтай зөвшилцөнө.

Ослын газарт очсон удирдах албан тушаалтан аюул ослын нөхцөл байдалтай танилцаж, аврах ажиллагааны удирдлагыг албан ёсоор аваагүй тохиолдолд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар зөвхөн санал гаргаж Шуурхай ажиллагааны дэвтэрт бичнэ.

Хэрвээ “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-нд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлж дууссан, хэрэгжүүлэх явцад үр дүн гарахгүй нь тодорхой болсон, аюулын нөхцөл байдал өөрчлөгдсөн тохиолдолд Ослын үеийн удирдагч, Аврах ажиллагааны ерөнхий удирдагч нар холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулан “Шуурхай ажиллагааны төлөвлөгөө” боловсруулна. Уг

төлөвлөгөөг Ослын үеийн удирдагч, Аврах ажиллагааны ерөнхий удирдагч нар батална.

Ослын үеийн удирдагч, аврах ажиллагааны ерөнхий удирдагч нар холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулан “Шуурхай ажиллагааны төлөвлөгөө”(3 дугаар хавсралт) боловсруулна.

Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө” ба “Шуурхай ажиллагааны төлөвлөгөө”-нд тусгагдаагүй гэнэтийн шийдвэрийг Ослын үеийн удирдагч, Аврах ажиллагааны ерөнхий удирдагч нар зөвшилцөн гаргаж энэ тухай шуурхай ажиллагааны дэвтэрт бичиж, хэрэгжүүлнэ.

Аврах ажиллагаа явуулж байгаа бүх тохиолдолд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллана.

Аврах ажиллагааны үр дүнг тодорхойлох, аврагчдын аюулгүй ажиллагааг хангах зорилгоор ослын үеийн удирдагч, Аврах ажиллагааны ерөнхий удирдагч нар ажиллагаа явуулж байгаа газарт байнга очиж танилцах үүрэгтэй.

Уурхайн аврах ажиллагааны аюулын үед , хүн, эд хөрөнгийг авран хамгаалах, эрж хайх, голомтоос гаргах, нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх, хор уршгийг арилгах үйл ажиллагааг зохион байгуулахад аврах ажиллагааны удирдлага зохион байгуулалтын зөв, оновчтой, хурдан шуурхай байх, аюулгүй ажиллагааг чанд баримталж ажиллах нь ажлын үр дүнгийн гол үндэс болдог.

Хоёр . Уул уурхайн аюулгүй ажиллагаа

Уул уурхайн аврах анги түүхэн хугацаанд 1591 хүний амь насыг уулын үйлдвэрийн ослоос авран хамгаалж, 19580 цэгт хий, тосны урьдчилан сэргийлэх шинжилгээний сорьц хийж, уулын нурал, усны цөмрөл, гал түймэр, хорт хийн ялгарал зэрэг ослоудад 400 гаруй мянган баг/цаг агааргүй, хорт хий бүхий хүнд халуун нөхцөлд ажиллаж, ил уурхайн галын цэгт 1550000 метр куб усан хөшиг татаж, хөргөлт хийн унтрааж, 200000 метр куб нурлыг сэргээж, 52000 метр куб бетонон хаалт хийн улсын болон ард иргэдийн өмч хөрөнгийг авран хамгаалах үүргээ амжилттай гүйцэтгэж иржээ.

Энэ бүх үйл явцад аврах ажиллагааны зөв зохион байгуулалт, нөр их хөдөлмөр орсон гэж ойлгомжтой.

Нийт ажилтнуудад нөөц гарцыг танилцуулах ажлыг 6 сар тутам хийж нөөц гарц өөрчлөгдвөл нэн даруй танилцуулах ёстой. Ажилтан үндсэн болон нөөц гарцтай танилцсан тухай тэмдэглэл хийсэн байна. Малталт, тэдгээрийн уулзвар бүрд уурхайгаас гадагш гарах чиглэл, зайг заасан гэрэлтдэг тэмдэг байна. Уурхайд ажилтан бүрд аврах багийг биедээ авч явна. Газрын доорх ажилтнуудын тооноос 10%-иар илүү тооны багийг бэлэн байдалд байлгана. Баг ашиглах шалгалтыг хагас жил тутам ажилтнаас авна. Ажилтан бүр уурхайд орохдоо багны бүрэн бүтэн байдалд биечлэн үзлэг хийнэ. Багийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу тогтоосон хугацаанд аврах нэгжийн мэргэжилтэн шалгаж, акт үйлдэнэ. Газрын доорх үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагааг

уул, уурхайн мэргэжлээр бакалавраас доошгүй боловсрол эзэмшсэн эсвэл мэргэшсэн ажилтан удирдана.

Уурхайн удирдлага болон инженер техникийн ажилтан нар уулын ажлыг горимоор нь явуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх үүднээс уурхайд тогтмол орж байх үүрэгтэй. Ээлж ахалж буй ажилтан ээлжийн хугацаанд ажлын байр бүрийг шалган, ажиллах нөхцөл хүндрэлтэй мөргөцөгт уулын ажлыг биечлэн удирдана. Ажлын байр нь аюулгүй байдлыг хангасан эсэхийг ажилтан ажил эхлэхийн өмнө шалгах ёстой. Ажилтан ээлжийн хугацаанд илэрсэн зөрчлүүдийг арилгах арга хэмжээг нэн даруй авах ёстой ба зөрчлийг арилгах боломжгүй бол ажлаа зогсоож, аюулгүй газар гарч, удирдлагад мэдэгдэх ёстой. Ажилтан бүр уурхайд үйлдвэрлэл болон аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх зөрчлийг илрүүлбэл, түүнээс сэргийлэх боломжит арга хэмжээг авч энэ тухай бусад ажилтнуудад анхааруулж удирдлагад мэдэгдэнэ. Удирдлага нь ээлж хүлээлцэх үед дараагийн ээлжийн ажилтнуудад гарч болзошгүй аюул ослын тухай заавал анхааруулах үүрэгтэй.

Орд газрыг нэг зэрэг ил, далд аргаар олборлох тохиолдолд ил, далд уурхайн аюулгүй байдлын дүрмийг баримталж ажиллана. Аюул учруулж болох болон ажил нь түр зогссон малталт руу орох хэсэгт хаалт эсвэл хориглох тэмдэг тавина. Ашиглахгүй байгаа босоо, налуу малталтыг доороос нь таглана. Ийм малталтыг агааржуулалтад ашиглах бол малталт

руу ажилтан унахаас сэргийлсэн найдвартай хаалт буюу төмөр тороор таглана. Газрын гадаргууд гарсан малталтын амсарт найдвартай хаалт эсвэл хашлага хийнэ. Ажилтан өргөх, буулгах зориулалттай механикжсан тоноглолтой босоо ба налуу малталтуудын ашиглалтын түвшингүүдэд хүлээлгийн байртай байна. Хүлээлгийн байрны гарцыг уурхайн амны ойролцоо байрлуулах ёстой. Хаагдсан малталт, уулын ажлаас шалтгаалж газрын гадаргуу дээр цөмрөл, нурал гарч болзошгүй хэсгийг тойруулан хашлага хийж анхааруулах тэмдэг тавина. Машинч тоног төхөөрөмжийн ойр орчимд ажилтан байгаа эсэхийг магадлаад анхааруулах дохио өгсний дараа ажиллуулах ёстой. Тоног төхөөрөмжийн дохиоллыг заасан самбар нь ойр, нүдэнд үзэгдэх газар байрласан байна. Ойлгомжгүй өгөгдсөн дохиог “Зогс” дохио гэж ойлгоно. Дохиог гүйцэд ойлгомжтой өгөгдөх хүртэл тоног төхөөрөмжийг ажиллуулахыг хориглоно. Цахилгаан эрчим хүч гэнэт тасарсан үед тоног төхөөрөмжийн тэжээлийг салгана. Эвдрэл, гэмтэлтэй тоног төхөөрөмжийг ажиллуулахыг хориглоно⁸³.

Дүгнэлт:

Уурхай, уулын үйлдвэрийн осол, түүний удирдлага зохион байгуулалтын талаарх онол, арга зүйг судлах, олон улсын туршлагын судалгаан дээр уурхай, уулын үйлдвэрийн осол, аврах ажиллагааны өнөөгийн байдалд шинжилгээ хийж,

түүнийг боловсронгуй болгох арга замыг тодорхойлоход.

Гамшгаас хамгаалах тухай хууль холбогдох төрийн хууль тогтоомжууд, уур амьсгалын өөрчлөлт, хөгжил чиг хандлага, улс эх орон нийгэм эдийн засгийн бодит байдал нийцүүлэн хэрэгжүүлэх, өндөр хөгжилтэй орнуудын туршлага стандартыг өөрийн орны онцлогт тулгуурлан хөгжилтэй орны ижил төрлийн байгууллагын жишигт ойртуулах нь стратегийн чухал зорилт юм.

Уул уурхай хөгжих хэрээр түүнийг дагаад техник технологийн горим алдагдаж уулын нуралт үүсэх буюу шууд болон шууд бус аваар осол гарах эрсдэл ихсэж аврах ажиллагаа зохион байгуулах шаардлага тулгарч, иймд Онцгой байдлын байгууллага, уул уурхайн ослын үеийн аврах ажиллагаагаа илүү сайжруулах шинэ хандлага бий болгож хөгжилтэй орны хэмжээнд үйл ажиллагаа нийцүүлэн сайжруулах нь чухал хэмээн үзэн байна.

Эх сурвалжийн жагсаалт

1. *Монгол Улсын* Гамшгаас хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/, УБ., 2017
2. Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрэм. Уул уурхайн сайд, Хөдөлмөрийн сайдын 2015 оны 229/А/232 дугаар хамтарсан тушаал
3. Ашигт малтмалын тухай хууль. 2006 он
4. Газрын тухай хууль. 2002 он

⁸³ Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрэм

- | | |
|--|---|
| <p>5. Уул уурхайн холбогдолтой хууль, тогтоомж (Албан ажлын хэрэгцээнд)УУХҮЯам. 2017 он</p> <p>6. Далд уурхайн олборлолтын аюулгүй ажиллагаа ба эрүүл ахуй. УБ хот 2007 он</p> | <p>7. С.Цэдэндорж Уул уурхайн үйлдвэрлэлийн технологийн үндэс УБ 2005.241</p> |
|--|---|